



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/280

Есөнбулаг сум

Терроризмтой тэмцэх салбар
зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.4, дахь заалт, Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоол, "Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажиллах журам"-ын 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг дахь Терроризмтой тэмцэх салбар зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 18,000,000 (арван найман сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаарагдах хөрөнгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалт, үр дүнг тайлагнаж ажиллахыг Терроризмтой тэмцэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

